

МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ СПОРТЫН АРБИТРЫН ДОПИНГИЙН ДАВЖ ЗААЛДАХ КОМИССЫН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

Допингийн эсрэг үндэсний дүрмийн 13 дугаар зүйлийн 13.10.12-т “Монголын Олон улсын болон үндэсний Спортын арбитрын хэрэг хянан шийдвэрлэх комиссын шийдвэр нь эцсийнх байх бөгөөд энэ дүрмийн 14.9-д заасны дагуу олон нийтэд мэдээлнэ”, Давж заалдах комиссын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн 20 дугаар зүйлийн 20.5-т “Давж заалдах комиссын шийдвэрийн эх хувь, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх хураангуй тайлбар эсхүл үр дүнг тодорхойлсон хэвлэлийн мэдээг Давж заалдах комисс олон нийтэд мэдээлнэ” гэж заасны дагуу олон нийтэд мэдээлж байна.

Шийдвэрийн дугаар: Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитрын допингийн Давж заалдах комисс 2026.01.23-ны өдрийн ДЗК-01/77 дугаар шийдвэр (хэсэгчлэн авав)

Төлөв: Хүчинтэй

Санамж: Энэхүү тойм нь шийдвэрийн эхийг орлохгүй бөгөөд олон нийтийг мэдээллээр хангах зорилготой болно.

Хэргийн дугаар: №25/02

1. Хэргийн оролцогчид ба Бүрэлдэхүүн

- **Өргөдөл гаргагч:** Э.Чойням (Үндэсний бөхийн тамирчин)
- **Хариуцагч:** Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага (МҮДЭБ) НҮТББ
- **Давж заалдах комиссын бүрэлдэхүүн:**
 - Даргалагч: Э.Золжаргал
 - Гишүүд: Ц.Бат-Энх, Д.Энхжин

2. Маргааны үндэслэл ба Талуудын тайлбар

- **Өргөдөл гаргагчийн байр суурь:** Э.Чойням нь 2025 оны Төв аймгийн 102 жилийн ойн баяр наадмын үеэр өгсөн допингийн шинжилгээгээр WADA (Дэлхийн допингийн эсрэг агентлаг)-ийн хориглосон жагсаалтын S.1.1 бүлэгт хамаарах *Dehydrochloromethyltestosterone*-ий метаболит илэрч, 4 жилийн хугацаагаар эрх хасах шийтгэл авсныг эсэргүүцсэн. Гомдлын үндэслэл:
 - **Процессын ноцтой зөрчил:** Шээсний сорьц авах үед эмэгтэй хянагч байлцсан нь "Сорьц авах ажилтан тамирчинтай ижил хүйстэй байна" гэсэн Олон улсын стандартыг зөрчиж, хүний халдашгүй байдал, эрхэм чанарт халдсан.
 - **Шийдвэрийн алдаа:** МҮДЭБ-ын мэдэгдэлд наадмын нэрийг "Хөвсгөл аймаг" гэж буруу бичсэн, бичгийн болон найруулгын ноцтой алдаатай тул Захиргааны ерөнхий хуульд заасан "захиргааны акт тодорхой байх" шаардлагыг хангаагүй.
 - **Гэм буруугийн хэлбэр:** Хориглосон бодисыг санаатай хэрэглээгүй. Абу Дабигаас авсан хүнсний нэмэлт бүтээгдэхүүний бохирдол эсвэл фитнесийн хамтрагчийн өгсөн өөх шатаагч цагаан эмнээс санамсаргүй байдлаар биед нэвтэрсэн. Сав баглаа боодолгүй эм өгсөн этгээдэд Цагдаагийн байгууллагаас зөрчлийн хэрэг нээж шалгасан тул дүрмийн дагуу шийтгэлийг цуцлах буюу хөнгөрүүлэх үндэслэлтэй.

- **Хөндлөнгийн нөлөөлөл:** МҮДЭБ-ын ажилтан С.Зүчи нь тамирчныг Арбитрт гомдол гаргах эрхээсээ татгалзахыг шаардаж дарамталсан, гэрч нарыг тусгаарлаж үг зааж өгөх зэргээр хяналтын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцсон гэж үзсэн.
- **Хариуцагчийн байр суурь:**
 - Тамирчны сорьцоос *Dehydrochloromethyltestosterone*-оос гадна *Boldenone* илэрсэн. Төсөв хүрэлцээгүйн улмаас IRMS (нарийвчилсан) шинжилгээг хийж чадалгүй, сорьцыг Герман дахь лабораторид 2026 оны эцэс хүртэл урт хугацааны хадгалалтад шилжүүлсэн. Тамирчин өөрөө ДНХ-ийн шинжилгээний зардлыг (4.2–4.7 сая төгрөг) гаргавал сорьц солигдсон эсэхийг шалгах боломжтой.
 - Тамирчин Допингийн хяналтын хуудсанд (DCF) "ажиллагаа стандартын дагуу явагдсан, тайлбар байхгүй" гэж сайн дураараа гарын үсэг зурсан. Мөн үл мэдэгдэх эмийг уусан нь дүрмийн дагуу "санаатай үйлдэл"-д тооцогдох тул 4 жилийн шийтгэл үндэслэлтэй.
 - Бичиг баримтын хувьд "Хөвсгөл аймаг" гэж техникийн алдаа гаргаснаа хүлээн зөвшөөрч, сорьц авах явцад эмэгтэй хүн байсанд уучлалт хүссэн боловч энэ нь шинжилгээний дүнд нөлөөлөхгүй. Гэрчид үр дагаврыг нь хууль ёсны дагуу анхааруулсан болохоос дарамтлаагүй. Комиссын хурал яригдахаас өмнө гэрчид гэрээний нөхцөл болон түүнийг зөрчсөн тохиолдолд үүсэх үр дагаврыг тайлбарласан. Учир нь тухайн гэрч өөрөө допингийн зөрчил гаргаж, нэг жилийн хөнгөлөлт авчихсан байсан тул уг хөнгөлөлт буцаж сэргэх аюултайг анхааруулах үүрэгтэй байсан гэж тайлбарлав.

3. Хэрэгт цугларсан нотлох баримтууд ба Үйл баримт

1. Шийдвэр, мэдэгдэл болон гэрээний баримтууд:

- **Шийтгэлийн баримт:** МҮДЭБ-аас 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр тамирчин Э.Чойнямд 4 жилийн хугацаагаар эрх хасах, тэмцээний үр дүнг хүчингүй болгох шийдвэрийн мэдэгдэл хүргүүлсэн. Уг баримтад наадмын нэрийг "Хөвсгөл аймаг" гэж алдаатай бичсэнээ хариуцагч тал хүлээн зөвшөөрсөн.
- **Эвлэрлийн гэрээ хүчин төгөлдөр бус байдал:** Хэрэгт авагдсан "Эвлэрлийн гэрээ" болон "Шийдвэрийг хүлээн зөвшөөрөх маягт"-д тамирчин Э.Чойням болон МҮДЭБ-ын төлөөлөгч Н.Ариунзаяа нарын хэн нь ч гарын үсэг зураагүй тул тамирчин шийтгэлийг сайн дураараа зөвшөөрсөн үйл баримт тогтоогдоогүй.
- **ДНХ шинжилгээний зардал:** Хариуцагч талаас сорьц солигдсон эсэхийг баталгаажуулах ДНХ шинжилгээг Герман улсын Дрезден хотын лабораторид 4.2–4.7 сая төгрөгөөр хийлгэх боломжтой гэж тайлбарласан ч энэ нь албан ёсны тарифт үнэ эсэх нь нотлогдоогүй.

2. Сорьц цуглуулах үеийн үйл явц ба Процессын алдаанууд:

- **Шинжилгээний хариу:** Тамирчин Э.Чойням нь 2025 оны 07 дугаар сарын 10-ны өдөр Төв аймгийн наадмын тэмцээний үеэр шинжилгээ өгсөн. Дрездений лабораторийн хариугаар 837371 дугаартай "А" сорьцоос хориглосон жагсаалтын S1.1-д хамаарах Дегидрохлорметилтестостероны метаболит илэрсэн.

- **Олон улсын стандарт зөрчсөн үйлдэл:** Шинжилгээ авах багт 4 эмэгтэй, 1 эрэгтэй ажилтан ажилласан. Үндэсний бөх нь эрэгтэйчүүдийн спорт атал анхнаасаа хяналтын ажилтнуудын хүйсний харьцааг зааж өгөөгүй МҮДЭБ-ын буруутай үйл ажиллагаа тогтоогдсон.
 - **Тамирчны эрхийг зөрчсөн байдал:** Эрэгтэй тамирчнаас эсрэг хүйсийн (эмэгтэй) хянагч яг харан зогсож шээсний дээж авсан нь тамирчныг ичээж, санаа зовоосон төдийгүй "ижил хүйстэй хүн дээж авахыг гэрчилнэ" гэсэн Олон улсын стандартыг ноцтой зөрчиж, тамирчныг гутаан доромжилсон үйлдэл гэж үзэв.
 - **Зохион байгуулалтын дутагдал:** МҮДЭБ нь дээж цуглуулах ажилтнуудтай олон улсын стандартын дагуу Ашиг сонирхлын зөрчлийн болон Ёс зүйн гэрээ байгуулаагүй, шинжилгээ авах байрны стандартыг урьдчилан баталгаажуулаагүй. Мөн тамирчинд эрх, үүргийг нь уншиж танилцуулаагүй, хяналтын хуудас бөглөх ажиллагаа замбараагүй явагдсан.
3. **Тамирчны үндсэн эрхэд халдсан ба Гэрчид нөлөөлсөн байдал:**
- **"Б" сорьц шинжлүүлэх эрхийг хаасан:** МҮДЭБ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч нь тамирчныг *"Б сорьц тэртэй тэргүй А сорьцыг батална, Арбитрт хандаад ялахгүй, манай захирал мундаг хуульч учир барахгүй, ахынхаа үгэнд орж 1 жил хасуул"* гэж дарамтлан, Арбитрт гомдол гаргах болон "Б" сорьцоо шинжлүүлэх үндсэн эрхэд нь халдаж, басамжилсан байна. МҮДЭБ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Зүчи үүнтэй маргаагүй.
 - **Гэрчийг заналхийлсэн ноцтой зөрчил:** МҮДЭБ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Зүчи нь шүүх хуралдаанд гэрчээр оролцохоор ирсэн тамирчин Э.Гантөмөрт хандан *"Хуралд орох юм бол чиний эвлэрлийн гэрээг цуцалж, шийтгэлийн жилийг чинь ихэсгэж нэмнэ"* гэж утсаар болон биечлэн заналхийлж, нөлөөлсөн нь тогтоогдсон.
 - **Комиссын шийдвэр:** Гэрчид нөлөөлсөн МҮДЭБ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Зүчийн энэхүү үйлдэл нь ноцтой зөрчил тул Дэлхийн допингийн эсрэг агентлаг (WADA)-д мэдэгдэж, хариу иртэл түүний үр дүнгийн удирдлагын үйл ажиллагаанд оролцох эрхийг түр түдгэлзүүлэхээр шийдвэрлэв.
 - **Нотлогдоогүй тайлбар:** МҮДЭБ-ын төлөөлөгчөөс *"Тамирчин Э.Чойням нь шинжилгээг солих, хүүхдээ шээлгэх, камер аргалах тухай ярьсан"* гэх тайлбарыг гаргасан боловч өргөдөл гаргагч өргөдлийн шаардлагадаа нэмэгдүүлж маргаагүй, хариуцагч сөрөг нэхэмжлэл болон холбогдох баримтыг гаргаж өгөөгүй тул уг үйл баримтын талаар дүгнэлт хийгээгүй орхив.
4. **Цагдаагийн байгууллагын баримтууд:**
- Сонгинохайрхан дүүргийн Цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн Тасгийн даргаас 2025 оны 08 дугаар сарын 18-ны өдөр Э.Чойнямд *"Иргэн Ц.Өлзийбаяр нь Э.Чойнямд өөх шатаагч бодис санал болгож өгсөн гэх хэрэгт Зөрчлийн тухай хуулийн 6.6 дугаар зүйлийг зөрчсөн болохыг тогтоосон тухай тодорхойлолт"* өгчээ.
 - СХД-ийн Цагдаагийн газраас 13 хуудас материал татаж үзэхэд иргэн Ц.Өлзийбаяр нь тамирчинд сав баглаа боодолгүй эм (өөх шатаагч) өгсөн үйлдэлд Зөрчлийн тухай хуулийн 6.6 дугаар зүйлийн 7.2-т заасан "допинг санал болгосон, худалдсан" гэх зөрчил тогтоогдоогүй тул хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан байна. 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн мөрдөгчийн

хэргийг хаах тогтоол гарсан бөгөөд уг тогтоолыг эс зөвшөөрвөл 5 хоногийн дотор Прокурорт гомдол гаргах эрхтэй талаар дурджээ. Өргөдөл гаргагчаас хэрэг бүртгэгчийн шийдвэрт гомдол гаргасан эсэх талаар баримт байхгүй, энэ талаар тайлбар өгөөгүй тул энэхүү баримтыг Бүрэлдэхүүн үнэлээгүй болно.

5. МҮДЭБ-ын хууль ёсны төлөөлөл, бүтцийн зөрчил (4.20, 4.21):

- **Удирдах эрх мэдлийн ойлгомжгүй байдал:** Улсын бүртгэлийн санд МҮДЭБ НҮТББ-ын Удирдах зөвлөлийн даргаар Ц.Уугангэрэл, гүйцэтгэх удирдлагаар Ж.Хатанбаатар бүртгэлтэй байна. Гэвч байгууллагын дүрмээс гадуур "Ерөнхийлөгч" Ц.Уугангэрэл гэж итгэмжлэл олгож байгаа нь хууль зүйн хувьд ойлгомжгүй, төлөөлөх эрх асуудалтай байгааг сануулав.
- **Хууль зөрчсөн бүтэц:** МҮДЭБ-ын дүрэмд заасан Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн нь 2025 оны 01 дүгээр сарын 01-нээс мөрдөгдөж эхэлсэн Биеийн тамир, спортын тухай хуулийн 27.5-д заасан *"Удирдах зөвлөл нь Хуульчдын холбоо, эрүүл мэндийн байгууллагын төлөөлөл бүхий 13 хүртэлх сондгой гишүүнтэй байна"* гэх шаардлагыг зөрчиж байх тул цаашид хуульд нийцүүлж ажиллахыг анхааруулж сануулав.

4. Бүрэлдэхүүний эрх зүйн дүгнэлт

Бүрэлдэхүүн цугларсан нотлох баримтууд, гэрчүүдийн мэдүүлгийг Дэлхийн допингийн эсрэг дүрэм (ДДЭД) болон Олон улсын стандартуудтай харьцуулан судалж, хариуцагч байгууллагаас тамирчны эрхийг ноцтой зөрчсөн, ажиллагаа хууль бус явагдсан болохыг дараах үндэслэлүүдээр тогтоов.

1. Шинжилгээ авах байр, баримт бичгийн стандартын зөрчил (5.1, 5.7, 5.9, 6.1):

- **Байрны шаардлага хангаагүй:** Шинжилгээ авсан өрөөг урьдчилан бэлдэж баталгаажуулаагүй, процессын өрөөг тусгаарлаагүй нь Шинжилгээ, мөрдөн шалгалтын Олон улсын стандартын (ШМШОУС) 6.3.2-т заасан тамирчны хувийн нууцлалыг хангах шаардлагыг зөрчсөн. Допингийн хяналтын ажилтан (DCO) уг зөрчлийг бүртгэх, өөр тохиромжтой байр хайх үүргээ биелүүлээгүй. Камерын бичлэг хийх, хянагчийн үүрэг давхардуулах зэрэг процессын алдаа гаргасан тул шинжилгээний үр дүнгийн хууль ёсны хүчин чадал эргэлзээтэй болсон.
- **Ажилтнуудын эрх зүйн чадамжгүй байдал:** Дээж авсан ажилтнууд МҮДЭБ-тай Ашиг сонирхлын зөрчлийн, Нууцлалын болон Ёс зүйн дүрмийн гэрээ байгуулаагүй нь ШМШОУС-ийн Хавсралт G.4.2-ыг зөрчсөн. Мөн тэдний DCO гэрчилгээ нь тамга, гарын үсэггүй байсан тул эрх бүхий ажилтан мөн эсэх нь нотлогдоогүй.
- **Допингийн хяналтын хуудас (DCF) хүчингүй:** Чапероны үүргийг өөр хүн давхар гүйцэтгэсэн, цаг, гарын үсэг, мэдэгдэл дутуу бөглөгдсөн тул DCF хуудас нь нотлох баримтын шаардлага хангахгүй.

2. Тамирчны үндсэн эрх, хувийн орон зайг ноцтой зөрчсөн байдал (5.2, 5.6, 6.2):

- **Хүйсний хамаарлын ноцтой гажилт:** Эрэгтэй тамирчнаас эмэгтэй хянагч ажиглан шээсний сорьц авсан нь ШМШОУС-ийн C.4.5 дахь *"Хянагч нь тамирчинтай адил хүйстэй байна"* гэсэн заавал мөрдөх (mandatory) шаардлагыг зөрчсөн ноцтой гажилт мөн. Энэ нь тамирчныг ичээж, гутаан доромжилсон үйлдэл бөгөөд "Тамирчны эрхийн тухай допингийн эсрэг Харти"-ийн 2 дугаар зүйлийг зөрчиж, тамирчны үндсэн эрхэд халдсан байна.

Бүрэлдэхүүн үүнийг нотолгооны үнэлгээг бүхэлд нь үгүйсгэх хэмжээний ноцтой зөрчил тул МҮДЭБ-аас гаргасан шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл гэж үзэв. Хариуцагч байгууллага үүнээс шалтгаалж сорьц бохирдоогүй гэдгийг нотлох үүргээ биелүүлээгүй.

- **"Б" сорьц шинжлүүлэх эрхийг хаасан:** МҮДЭБ-ын ажилтан С.Зүчи тамирчныг айлган сүрдүүлж, дарамталснаас үүдэн тамирчны "Б" сорьц шинжлүүлэх суурь эрх бодитоор хангагдаагүй. Энэ үйлдэл нь Дэлхийн допингийн эсрэг дүрмийн (ДДЭД) 7, 8.1 (Шударга сонсголын эрх) болон 20.1.1 (Тамирчны үндсэн эрх)-д заасан шударга процессын баталгааг (Due process) алдагдуулсан ноцтой гажилт тул WADA-д мэдэгдэхээр шийдвэрлэв.
3. **Үр дүнгийн удирдлага ба Хариуцлага тооцсон шийдвэрийн хууль бус байдал (5.3, 5.4, 5.5, 5.8, 6.3):**
- **Эхний хянан үзлэг хийгээгүй:** МҮДЭБ нь сөрөг илэрц гарсны дараа Үр дүнгийн удирдлагын олон улсын стандартын (ҮДУОУС) 5.1.1-д заасан эхний хянан үзлэгийг (Олон улсын стандартаас гажсан байдал байгаа эсэхийг шалгах үүрэг) огт хийгээгүй.
 - **Мэдэгдлийн алдаа:** Анхны мэдэгдэлд наадмын нэрийг "Хөвсгөл аймаг" гэж буруу бичсэн, огноо, хариуцах байгууллага тодорхой бус байсан нь ҮДУОУС-ийн 5.3.2.2, 5.3.2.3 заалтыг зөрчсөн процедурын ноцтой алдаа (Serious Procedural Violation) мөн бөгөөд процессын итгэлцлийг алдагдуулсан.
 - **Тамирчны тайлбарыг үл хэрэгссэн:** Тамирчны гаргасан "санамсаргүй хэрэглээ, цагдаагийн тодорхойлолт" зэрэг баримтуудад нарийвчилсан хууль зүйн дүн шинжилгээ хийлгүй, хүсэлтэд нь хариу өгөлгүй шууд шийтгэсэн нь ҮДУОУС-ийг зөрчсөн процедурын ноцтой алдаа болно.
 - **Шийдвэр тодорхойгүй, зөрчилтэй:** МҮДЭБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын өгсөн "Мэдэгдэл" нь албан ёсны шийдвэр эсэх нь тодорхойгүй, огноо, дугааргүй. Байгууллагын Ерөнхийлөгч нь "4 жилээр эрх хассан" гэх тайлбар ирүүлсэн атал итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Зүчи нь "үр дүнгийн удирдлага дуусаагүй" гэж хоорондоо эсрэг тэсрэг байр суурь илэрхийлсэн. Иймд Бүрэлдэхүүн МҮДЭБ-аас оногдуулсан 4 жилийн эрх хасах шийдвэрийг хууль бус гэж дүгнэн, шийдвэрийг хүчингүй болгох нь зүйтэй гэж үзэв.
 - **Гэрээ хүчин төгөлдөр бус байдал (6.5, 6.6):** Хэрэгт авагдсан Эвлэрлийн гэрээ болон Хүлээн зөвшөөрөх маягтад талууд гарын үсэг зураагүй тул Иргэний хуулийн 43.2.1-д заасан шаардлагыг хангахгүй, байгуулагдаагүй хүчин төгөлдөр бус хэлцэл гэж үзнэ.
4. **Давж заалдах эрхийг хязгаарласан ба гэрчид хууль бусаар нөлөөлсөн нь (5.10, 5.12):**
- **Эрх хязгаарлах оролдлого:** ДДЭД-ийн 13.2, 13.3-т зааснаар допингийн байгууллага цаг хугацаанд нь шийдвэр гаргаж чадаагүй, эсхүл процедурын ноцтой зөрчил гаргасан үед тамирчин эцсийн шийдвэрийг хүлээлгүй давж заалдах журмаар эрхээ хамгаалуулах эрхтэй. Хариуцагч тал "үр дүнгийн ажиллагаа дуусаагүй" гэх үндэслэлээр хэргийг хаахыг оролдсон нь тамирчны эрхийг хязгаарласан хууль бус үйлдэл юм.
 - **Гэрчийг айлган сүрдүүлсэн зөрчил:** МҮДЭБ-ын ажилтан С.Зүчи нь гэрч Э.Гантөмөрт "Хуралд гэрчээр орвол эвлэрлийн гэрээг чинь цуцалж, шийтгэлийн жилийг чинь ихэсгэнэ" гэж заналхийлсэн нь ДДЭД-ийн 2.5, Үндэсний дүрмийн 2.4.5-д заасан "Допингийн хяналтын үе шатанд

хөндлөнгөөс оролцох, оролцохоор завдах" олон улсын хэмжээний хамгийн ноцтой зөрчилд хамаарна. Ийм нөхцөлд гарсан шийдвэр хүчин төгөлдөр байх боломжгүй тул ДДЭД-ийн 7.4.2-т зааснаар WADA-аас хариу ирэх хүртэл ажилтан С.Зүчийн допингийн эсрэг үйл ажиллагаа, үр дүнгийн удирдлагад оролцох эрхийг түр түдгэлзүүлэхээр шийдвэрлэв.

5. **Байгууллагыг төлөөлөх эрх болон хуулийн хэрэгжилтийн тухай (5.11, 5.13, 6.7):**
- **Төлөөлөх эрхийн тухайд:** Улсын бүртгэлд гүйцэтгэх удирдлагаар Ж.Хатанбаатар бүртгэлтэй атлаа Ц.Уугангэрэл "Ерөнхийлөгч" гэж итгэмжлэл олгосон нь зөрчилтэй ч Бүрэлдэхүүн Ц.Уугангэрэлийг төлөөлөх эрхтэй этгээд гэж дүгнээд, бүртгэлийн зөрчлөө арилгахыг сануулав. Мөн МҮДЭБ-ын эрх зүйн байдлыг хууль бус гэх өмгөөлөгчийн тайлбар үндэслэлгүй бөгөөд Допингийн давж заалдах комисс үүнийг шийдвэрлэх боломжгүй, Иргэний хуулийн 9.1-9.3-ын дагуу тусдаа шүүхээр шийдвэрлүүлэх боломжтой.
 - **Бүтцийн тухайд:** МҮДЭБ-ын дүрэмд Удирдах зөвлөлийг 4 жилээр, 6 хараат бус гишүүнтэй сонгохоор заасан нь 2025 оны 01 дүгээр сарын 01-нээс мөрдөгдөж буй Биеийн тамир, спортын тухай хуулийн 27.5, 27.7-д заасан шаардлагыг (Удирдах зөвлөл нь Хуульчдын холбоо, эрүүл мэндийн байгууллагын төлөөлөл бүхий 13 хүртэлх сондгой гишүүнтэй, 3 жилийн хугацаатай нэг удаа сонгогдоно) зөрчиж байна. МҮДЭБ нь Монгол Улсын хуулийг чандлан сахих үүрэгтэй тул бүтцээ хуульд нийцүүлэн шинэчлэхийг үүрэг болгов.

5. Тогтоох хэсэг (Шийдвэр)

1. Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага (МҮДЭБ) НҮТББ-аас үндэсний бөхийн тамирчин Энхболдын Чойнямд оноосон 4 жилээр эрх хасах шийтгэлийг гаргахдаа шударга, ил тод, хараат бус байх зарчмыг ноцтой зөрчсөн гэж үзсүгэй.
2. Үндэсний бөхийн тамирчин Э.Чойнямд 2025 оны 7 дугаар сарын 10-ны өдөр авсан шинжилгээтэй холбоотой гарах үр дагавар, оноосон шийтгэлийг хүчингүйд тооцож, Э.Чойнямын барилдах эрхийг сэргээсүгэй.
3. Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага (МҮДЭБ) НҮТББ-д Биеийн тамир, спортын тухай хуулийн 27.5, 27.7 дахь хэсэгт заасан хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг сануулсугай.
4. Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага (МҮДЭБ) НҮТББ-ын ажилтан С.Зүчийн тамирчин болон гэрчид нөлөөлсөн талаарх асуудлыг Дэлхийн допингийн эсрэг агентлаг (WADA)-д мэдээлсүгэй.
5. Дэлхийн допингийн эсрэг агентлагт мэдээлсэнтэй холбогдуулан хариуг ирэх хүртэл Монголын Үндэсний Допингийн эсрэг байгууллагын ажилтан С.Зүчийн Допингийн эсрэг үйл ажиллагаанд оролцох эрхийг түр түдгэлзүүлсүгэй.
6. Талууд энэхүү шийдвэрийн талаар Дэлхийн допингийн эсрэг дүрмийн 13.2.3.5-д заасны дагуу Олон улсын спортын арбитрын шүүхэд (CAS) гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.
7. Энэхүү шийдвэр нь гарсан дариу хүчин төгөлдөр болно.